


ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮН

ТОВХИМОЛ

6

ӨРХИЙН ЭМЧИЙН ГАРЫН АВЛАГА



Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 оронд хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус, олон улсын байгууллага юм. Монгол Улсад 1994 оноос тогтвортой үйл ажиллагаа явуулж, Боловсрол, Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрүүдийн хүрээнд үйлажиллагаагаа явуулж байна.

©Хүүхдийг Ивээх Сан, 2016 он

Боловсруулсан: Д.Оюунсүрэн
Хянан тохиолдуулсан: Х.Өлзийтунгалаг
Гарын авлагын зургийг Г.Ганбаяр

Хүүхдийг Ивээх Сан
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
I дүгээр хороо, Аризона төв, 4-р давхар

Шуудангийн хайрцаг:
Төв шуудан, ш/х-1023, Улаанбаатар хот 13, Монгол Улс

Утас: +976-11-329365,
+976-11-329371

Факс: (976-11) 329361

И-Мейл: secretary@savethechildren.mn

Facebook: Save the Children in Mongolia

Twitter: Save the children MN

Вэб: www.savethechildren.mn

ӨРХИЙН ЭМЧИЙН ГАРЫН АВЛАГА

ӨРХИЙН ЭМЧ БА ХАМТАРСАН БАГ

Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамтарсан багийн гишүүн болох өрхийн эмч дараах үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

- ✓ Хамтарсан багийн гишүүдтэй хамт гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны ажил явуулах;
- ✓ Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ буюу үзлэг шинжилгээ хийх, зөвлөгөө өгөх, гэрийн эргэлтийн үед гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй байгаа, эсвэл сэжиглэж буй тохиолдолд нийгмийн ажилтанд мэдэгдэх;
- ✓ Хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй хүүхдийн зовиур, сэтгэл санааны дарамт, бие махбодын бэртэл гэмтэл, үйл ажиллагааны алдагдлыг нарийвчлан тэмдэглэж баримтжуулах;
- ✓ Үзлэгийн явцад хүчирхийллээс болж хүүхэд эрүүл мэндээрээ хохирсон, бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна гэсэн дүгнэлтийг хийсэн бол эмнэлэг, хорооны нийгмийн ажилтанд нэн даруй мэдэгдэх;
- ✓ Хүчирхийллээс болж эрүүл мэндээрээ хохирсон хүүхдэд эрчимтэй, богино болон урт хугацааны эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх;
- ✓ Хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдэд мэргэжлийн хүрээнд мэдээлэл, зөвлөгөө өгөх;
- ✓ Гэр бүлд нь буцаах, эргэн нийгэмшүүлэх үйлчилгээний үед хүүхдийн эрүүл мэндийн байдалд хяналт, үнэлгээ хийх;
- ✓ Өрхийн эмч, сувилагч нь хохирогч хүүхдийг зөв оношлох, эрчимтэй болон урт хугацаанд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн үзлэг эмчилгээнд холбох, гэр бүлд нь буцаах, эргэн нийгэмшүүлэх үйлчилгээний үед хүүхдийн бие, сэтгэцийн эрүүл мэндийн байдалд хяналт үнэлгээ хийх зэрэг үйлчилгээг үзүүлэх;
- ✓ Хамтарсан багийн хуралдаанд оролцож мэргэжлийн үнэлгээ дүгнэлтээ хуваалцах;
- ✓ Бүртгэл мэдээллийг нэгтгэн, дээд шатны байгууллагад тайлагнах;
- ✓ Өртөмхий бүлгийн гэр бүл, хүүхэд залуустай холбоо тогтоох, тухайн гэр бүлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулах;
- ✓ Хүүхэд болон гэр бүлийн бусад гишүүний аль алинд нь анхаарал хандуулан зохих үнэлгээг хийх;
- ✓ Өртөмхий бүлгийн гэр бүл, хүүхдийн тухай мэдээллийг багийн болон өрхийн эмнэлгийн бусад гишүүдтэй хуваалцах;
- ✓ Хүчирхийллийн болон эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц бусад нөлөөллийн үр дагавар, шинж тэмдгийг илрүүлэн үнэлэх;

- ✓ Шаардлагатай анхан шатны тусламжийг үзүүлэх;
- ✓ Зохих байгууллага, албан тушаалтанд хамгаалал шаардлагатай, ахих шатны тусламж хэрэгцээтэй хүүхдийн тухай мэдээлэх, холбон зуучлах;
- ✓ Чиг үүргийнхээ хүрээнд холбогдох хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх;

7 дугаар зүйл. Эрүүл мэндийн үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал

7.1. Эрүүл мэндийн ажилтан нь ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид заавал мэдээлнэ.

7.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүсэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна.

7.3. Эрүүл мэндийн байгууллага нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлнэ.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас



ХАМТАРСАН БАГИЙН БУСАД ГИШҮҮДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ НЬ

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних, илрүүлэх, оношлох, эмчлэн илааршуулах, мэдээлэх

Хүчирхийлэлд өртөх эрсдлийн үнэлгээг өрхийн эмч, сувилагч дараах чиглэлээр түлхүү анхаарч хийнэ.

Эцэг эхээс хамааралтай эрсдэлийн хүчин зүйлс

- Хувийн зан араншин ширүүн догшин байх
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай байх
- Дагавар болон өргөмөл хүүхэддээ ялгавартай ханддаг байх
- Бага насандаа хүчирхийлэлд өртөж байсан түүхтэй
- Архи, мансууруулах бодисын хамааралтай байх

Хүүхдээс хамааралтай эрсдлийн хүчин зүйлс

- Хүүхдийн нас бага байх тусам эрсдэлд өртөх магадлал илүү
- Хөгжлийн бэрхшээлтэй байх
- Өсөлт хөгжлийн хоцрогдолтой байх
- Зан авирын доголдолтой байх
- Сургууль засвардсан байх, сурах идэвхи сонирхол муу байх
- Хагас болон бүтэн өнчин байх
- Бичиг баримтгүй байх
- Орон гэрээсээ дайжиж хараа хяналтгүй амьдарч байгаа



- Хамгаалал шаардлагатай тохиолдлын тухай хамтран хэлэлцэж, үйл ажиллагааны явцыг хамтран хянах
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийг урьдчилан сэргийлэх, анхдагч болон хоёрдогч урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад хамтран ажиллах, эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл, сургалт сурталчилгааг хөтлөн явуулах
- Гэр бүлд чиглэсэн боловсрол олгох
- Давтан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гаргах, бусад гишүүдтэй хамтран ажиллах

ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

I. Хүүхэдтэй харилцах онцлог

Өрхийн эмч хүүхдийн хөгжлийн онцлогийг мэдэж, хүүхэдтэй харилцах шаардлагатай.

Бага насны хүүхэдтэй харилцах онцлог (5 хүртэлх нас)

- Эцэг эх, асран хамгаалагч нарын хамт байлгах
- Аль болох эелдэг, дотно найрсаг уур амьсгал бүрдүүлэх
- Айдас, түгшүүрийг багасгах зорилгоор сонирхол татахуйц тоглоом, зурагт үзүүлэн, хуудас гэх мэтийг ашиглаж болно.
- Эмч, сувилагчийн хувцаслалт, үзлэгийн өрөөний тохижилт хүүхдийн анхаарлыг татахуйц байх
- Эмчийн хэрэглэж буй үзэг, бал сонирхолтой хэлбэр бүхий зурагтай байх нь бага насны хүүхдийн айдас, болгоомжлолыг бууруулдаг гэдгийг анхаарах
- Хүүхэдтэй өхөөрдсөн дуугаар мэндлэн, байнга өөрт нь хандсан яриа, асуулт, тайлбар хийх
- Үзлэгийн явцад уйлахаа больж, хөдөлгөөнтэй, өрөөн дотуур чөлөөтэй холхиж, энэ тэр юмыг сонирхож эхлэх нь тэрээр тайвширч айж эмээх, болгоомжлох нь багасаж байгаагийн илрэл учраас дэмжих харилцааг бий болгох
- Үзлэг хийхдээ асран хамгаалагч, эцэг эхийнх нь өвөр дээр суулгасан байвал хүүхдэд таатай байдаг
- Хүүхдийн биед хүрэхээс өмнө гар болон чагнуураа дулаан болгож, аль болох зөөлөн, цочроолгүй хүрэлцэх нь тохиромжтой
- Үзлэг дууссан хойно хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нараас лавлах зүйлээ тодруулан асуух, хүүхдийн биеийн байдал, оношилгоо, эмчилгээтэй холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх
- Хүүхдийг нэрээр нь дуудан, “баяртай” хэмээн хэлж үдвэл илүү таатай байх бөгөөд харилцаа улам бэхжинэ.

6 ба түүнээс дээш насны хүүхэдтэй харилцах онцлог

- 6 ба түүнээс дээш насны хүүхэдтэй аль болох ганцаарчилсан ярилцлага өрнүүлэх нь хүүхэд өөрийн үгээр, бие даан өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгоно. Ийм насны хүүхэдтэй аль болох дотночилон ярилцахыг хүсвэл нүдний харц, нуруу нэг төвшинд, үе тэнгийн найз нь мэт байхуйц байрлал сонгох нь чухал байдаг.
- Гэтэл ихэнхи тохиолдолд эмч нар хүүхэдтэй харилцахдаа дээрээс доош чиглэл бүхий, “том хүн” гэдгээ сануулах мэт нуруу өндөр байдалтай суух, эсвэл зогсож, захирангуй, зандарсан дууны өнгөөр ярих нь тэдэнтэй чөлөөтэй илэн далангүй харилцааг өрнүүлэхэд саад учруулж “хаалттай харилцаа” үүсгэдэг.

Өсвөр насны хүүхэдтэй харилцах онцлог

- Өсвөр нас гэдэг нь бэлгийн бойжилт болон насанд хүрсэн үе рүү шилжих шилжилттэй холбоотой чанарын өөрчлөлтөөр тодорхойлогдох хүүхэд нас болон насанд хүрсэн үеийн хооронд орших онтогенетик хөгжлийн үе шат (11–12 наснаас 16–17 нас хүртэл)

Энэ насанд хувь хүн:

- o Хөөрөл ихтэй
- o Импульсив (ухамсрын хяналт сул, гадаад нөлөөлөл болон сэтгэл хөдлөлдөө хөтлөгдөж үйлдэх хандлагаар илрэх зан төлвийн шинж чанар. Насны онцлогийн хувьд энэ чанар сургуулийн өмнөх болон сургуулийн бага насанд ихэвчлэн илэрдэг хэдий ч өсвөр насанд өсөн нэмэгдэх сэтгэл хөдлөлийн хөөрөлтэй холбоотойгоор дахин илэрдэг онцлогтой)
- o Өөрийн ухамсар бүрэлдэх, Би–үзэл баримтлал өөрчлөгдөх, өөрийгөө, өөрийн боломжийг ойлгох гэсэн оролдлого хийгддэг үе
- o Анализ–синтез үйл ажиллагааны нарийн хэлбэрүүд бүрэлдэж, хийсвэр, онолын сэтгэхүй хөгждөг
- o Үе чацуутны бүлэгт харьяалагдах мэдрэмж хүчтэй илэрдэг

Өсвөр насны хүүхэдтэй харилцах, үзлэг хийх, зөвлөгөө өгөх үйл ажиллагааны олон арга хэлбэр байдгаас “LEPER”, “GATHER”–ийн аргуудыг өргөн ашигладаг байна.

LEPER–ийн арга	GATHER–ийн арга
L–Listening – Зовиур шаналгаа, санааг нь зовоож буй зүйлсийнх нь талаарх яриаг тэвчээртэй, чин сэтгэлээсээ ойлгож сонсох	G–Greet – үйлчлүүлэгч хүүхэдтэй дотночилон мэндчилж, нэрийг асуун танилцаж хүндэтгэлтэй хандах
E–Explaining – Оношилгоо, эмчилгээтэй холбоотой зүйлсийг тайлбарлаж өгөх	A– Ask – Яагаад эмчид хандаж буйг асууна.
P–Providing information– Шаардлагатай зохих мэдээллээр хангах	T– Tell – Асуудлыг шийдвэрлэхэд туслах арга зам, шаардлагатай мэдээллийг хэлж өгнө.
E– Examining – Ойлгож байгаа эсэхийг нь асууж тодруулан, шалгах	H–Help – Оновчтой шийдвэр гаргах, зөв арга замыг сонгоход нь туслах
R– Reducing anxiety– Айдас, түгшүүрийг нь багасгах нөхцлийг бүрдүүлэх	E–Explaining – сонгосон арга замаа хэрэгжүүлэхэд юу хийвэл зохихыг тайлбарлаж өгнө.
	R– Return– Дахин ирэхийг зөвлөх

Adopted from Rinehart, W., Rudy S. and Drennan, M. GATHER Guide to Counseling. Population Reports, Series J, No. 48, Baltimore, Johns Hopkins University school of Public Health, Population Information Program, December 1998.

Өсвөр насны хүүхдийн сэтгэлзүйн асуудлыг тодорхойлохын тулд зайлшгүй асууж тодруулах шаардлагатай сэдвүүд байдаг. HEEADDSSS нь ДЭМБ-аас батлан гаргасан өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэхэд ашиглах аргачлал бөгөөд дараах чиглэлийн дагуу мэдээлэл цуглуулах юм. Үүнд:

H-Home: Гэр бүл, эцэг эх, гэрийн дотоод харилцаа, уур амьсгалын талаарх мэдээлэл

E-Education: Боловсрол, сургуультай холбоотой мэдээлэл

E-Employment: Хэрэв ажилладаг бол, ажлынх нь талаарх мэдээлэл

E-Eating: Хооллолттой холбоотой асуудал

A-Activities: Ямар үйл ажиллагаанд оролцдог, чөлөөт цагаа хэнтэй, хэрхэн өнгөрүүлдэг гэх мэт мэдээлэл

D-Drugs: Мансууруулах эм бодисын хэрэглээтэй холбоотой мэдээлэл

D-Depression: Сэтгэл зовоосон асуудал, сэтгэл гутрал, сэтгэл санааны байдлын мэдээлэл

S-Sexuality: Бэлгийн бойжилт, бэлгийн амьдралтай холбоотой мэдээлэл

S-Suicide: Амиа егүүтгэх эрсдэл бий эсэхийг тодруулах

S-Safety: Аюулгүй байдлын талаар (осол, гэмтэл, хүчирхийллээс хамгаалагдсан эсэх) тодруулах асуултууд багтана.

(Adapted from Contemporary Pediatrics, Getting Into Adolescent Heads—July 1988, by John M. Goldenring, MD, MPH, & Eric Cohen, MD)

Өсвөр насныхантай холбоотой аливаа асуудалд хүүхдийн эрхийг хүндэтгэх үүднээс өөрөөс нь, асран хамгаалагч нараас зөвшөөрөл авахын хамт бие даан сонголт хийх боломжийг хангах нь өсвөр насны хүүхдийн эрүүл эсэн мэнд амьдрах, суралцах, улмаар сэтгэлзүйн эрүүл байдлыг хамгаалан дэмжих чухал нөхцөл болдгийг анхаарах хэрэгтэй.

Сэтгэлзүйн элдэв асуудал тулгарсан хүүхэд, өсвөр насныханд үе тэнгийнхний зүгээс тэднийг шоолж, нэр хоч өгөх зэргээр ялгаварлан гадуурхах явдал цөөнгүй тохиолддог. Ийнхүү ялгаварлан гадуурхах нь сэтгэлзүйн асуудалтай хүүхдийг улам таагүй байдалд оруулж, улмаар тэднийг нийгмээс тусгаарлах, зожиг ганцаардмал болгох үр дагавартай.



II. Хүүхдийн биед ерөнхий үзлэг хийх

Хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй хүүхдэд биеийн ерөнхий үзлэг хийх нь энгийн хоёр шалтгаантай. Эмнэл зүйн талаасаа өмнө нь мэдэгдээгүй, хүчирхийлэлтэй холбоогүй гэмтлүүдийг олж илрүүлэх нь хүчирхийлэлд өртсөн эсэхийг батлахад ач холбогдолтой.

Энэ нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн гэмтлийг илрүүлэхэд тус болно.

Хүчирхийлэлд өртсөн ихэнх хүүхдүүд тэдний биед ямар нэг өөрчлөлт орсныг мэдэрдэг тул үзлэг хийлгэх нь тэдний биед гэмтэл төдийгүй ямар өөрчлөлт орсныг илрүүлж чадна гэж тэд үздэг. Эмч үзлэг хийж, зөвлөгөө өгснөөр түүний бүх зүйл хэвийн харагдаж, түүний бие ч гэсэн “сайн” байгааг ухаарахад тус болно.

Хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй хүүхдэд үзлэг хийхдээ дараах зүйлийг анхаарч, үнэлгээ хийнэ:

- Хөгжлийн үзүүлэлт болох хөдөлгөөн, харах сонсох, ярих, тоглох чадварыг үнэлэх
- Сэтгэл хөдлөлийн байдлыг тодорхойлох
- Өсөлтийн үзүүлэлт жин, өндөр, бугалга, толгойн тойргийг хэмжих
- Бүх биеийг анхааралтай үзэж хавдар, булдруу, согог, өнгөний өөрчлөлт, ясны болон дотор гэмтэл байгаа эсэхийг шалгах
- Инвазив бус аргаар бэлэг эрхтнийг шалгах (охиодод толь тавихгүй үзэх)



- Өгзөг, хонго, гуяны ард, тахим тушаа хөхрөлт байна уу?
- Чихний гэдэс, хацар дээр хурууны ором хээ бүхий хөхрөлт байна уу?
- Бэлэг эрхтэн орчмоор хоорондоо их ойрхон хоёр хагас дугуй сорви (чимхсэн байж болохуйц) байна уу?
- Бэлэг эрхтэнд гүн ховил үүссэн байна уу?
- Бэлэг эрхтэнд том хүний шүдний ором гарсан байна уу?
- Бэлэг эрхтэнээс цус гарсан байна уу?
- Нярай, мөлхөө хүүхдийн дээд уруулын гадна ба дотор талд хөхрөлт, урагдалт байна уу?
- 6–8 сараас доош насны хүүхдэд уруул нь урагдсан, хэгзэрсэн байна уу?
- Хүзүүнд хөхрөлт байна уу?
- Биен дээр маажсан, самардсан, цохиж чимхсэн, ороолгуулсны улмаас үүссэн хөхрөлт байна уу?
- Хүн хазсан байж болзошгүй хагас дугуй хэлбэртэй шүдний ором бүхий шарх сорви байна уу? (шүдний эмчээр том хүнийх үү, хүүхдийнх үү гэдгийг тодорхойлуулах шаардлагатай)
- Ойролцоогоор 2.5–5 см орчим урт нарийхан хөхрөлт байна уу? (бүсний гархи, нүхний ором тод гарсан байх)
- Арьсанд гогцоорсон ором байна уу?
- Хөхрөлт, гөвдрүү зэрэг нь хачин этгээд хэлбэртэй, геометрийн дүрс бүхий байвал
- Хүүхдийн арьсан дээр зүү үзэг, тонгорог зэрэг хурц үзүүртэй зүйлээр шивсэн ммэт ором байвал
- Хөл, шагай, бугуйнд арьс нь зүсэгдсэн, эсвэл зулгарал цэврүү болсон байвал
- Бие махбодод бий болсон эдгээр шарх шалбархай нь эдгэрэлтийн харилцан адилгүй үе шатанд байвал

- Нэг төрлийн, дугуй хэлбэртэй, хэвээр дарсан мэт, хэмжээний хувьд нэг хэвийн түлэгдэлтийн ором байна уу?
- Халаадаг хэрэгслүүд болох индүү, радиаторын ором бүхий, халуун плитка, ялтсан халаагуурт түлэгдсэн хэлбэр, гарын сарвуу түлэгдсэн байх, цэрвүүгүй, голдуу 2–р зэргийн түлэгдэл үүсэн байна уу?
- Сам, хутга, түлхүүр, иржгэр ултай индүү, тамхины асаагуурын халсан таг зэрэгтэй адил хэлбэртэй түлэгдэлтийн шарх байвал
- Гуя, хөлийн ар тал, хонго, бэлэг эрхтэн, хошного орчмоор тодорхой тусгаарлагдсан хүрээгээр үүссэн, шарх нь тал тал тийшээ тараагүй тодорхой хэлбэртэй түлэгдэлт байна уу?
- “Оймсон” эсвэл “бээлийн” түлэгдэлт байна уу?

- Толгойд цусан толбо үүссэн байна уу?
- Толгойд хэд хэдэн газар нэгээс илүү гэмтэл үүссэн байна уу?
- Толгойд том том халцархайнууд үүссэн байвал (удаагүй бол хуйх хавдана, цус гоожно)
- Нүд хөхөрсөн байна уу?
- Толгойд гэмтэл бэртэл байхын зэрэгцээ үргэлж айх цочих, бөөлжих, чөлөөтэй амьсгалж чадахгүй байх, татах зэрэг тодорхой шинж тэмдэг мэдэгдэж байна уу?

- Гэдэс, хэвлий гаднаа хөхөрсөн байна уу?
- Бөөлжих, хэвлийгээр өвдөх, цус багадалтын шинж богино хугацаанд мэдэгдэхүйц илэрсэн байна уу?
- Мушгирсан эсвэл хугарал нь хөл эсвэл гарт байвал
- Хавирга, дал, эгэм, өвчүүний гэмтэл бэртэл илэрсэн байвал

Бие махбодын хүчирхийлэлд өртсөн байж болно

- Биеийн жин байх ёстой хэмжээнээсээ хэт бага, тураалд орсон байна уу?
- Хувийн ариун цэвэр муу байвал
- Өсөлт хөгжлийн доройтол, хоцрогдолтой байна уу?
- Арьсны өнгө гундуу байна уу?

Үл хайхрах байдалд өртсөн байж болно

- Хэт их иддэг эсвэл бараг юу ч идэхгүй байна уу?
- Хүмүүстэй болон эцэг эхтэйгээ харилцах чадвар дутмаг байна уу?
- Ямар ч хамаагүй хүмүүсээс салахгүй зууралдаж байна уу?
- Танихгүй хүмүүсийг дагаад байна уу?

- Тухайн хүүхэд ууртай догшин, хэрцгий зан авиртай байна уу?
- Хичээл сурлагандаа муудаж байна уу?
- Хичээлд анхаарлаа төвлөрүүлэхэд бэрхшээлтэй, хичээлээ ойлгохоо больж байна уу?
- Орондоо болон өмдөндөө шээдэг болсон уу?
- Бохир, халтар, арчаагүй байх болсон уу?
- Бусдын анхаарлыг татахыг хичээсэн зан авир байнга гаргадаг болсон уу?
- Сэтгэл санааны гүнзгий хямралын шинж илэрч байна уу?

Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байж болно

- Бэлэг эрхтэн болон шулуун гэдэсний орчмоор өвдөлттэй эсвэл гэмтсэн байна уу?
- Хөх, өгзөг, хэвлийн доод хэсэг, ташаа гуя ормоор хөхөрсөн байна уу?
- Үтрээ болон шээсний замын үрэвсэлтэй байна уу?
- Бэлгийн замын халдварын шинжүүдээс илэрч байна уу?
- Жирэмсэлсэн байна уу?

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болно

- Тухайн хүүхэд насандаа баймгүй бэлгийн харилцаа болон бэлгийн зан үйлийн талаарх мэдлэгтэй байна уу?
- Зураг зурах, ярих, тоглохдоо бэлгийн харилцааны асуудлыг хөндөж байна уу?
- Архи, мансууруулах бодис хэрэглэх, өөрийгөө зэрэмдэглэх, амиа егүүтгэхийг оролдох гэх мэтийн эрсдэлтэй алхмууд хийх болон өөртөө хор хөнөөл учруулахыг оролдсон уу?
- Орондоо шээх, эсвэл усанд орохгүй халтар царайлах гэх мэт байдалтай болсон уу?
- Хүмүүжилтэй байсан хүүхэд хэрэг төвөгт орооцолдож эхэлсэн үү?
- Хооллох дур хүсэл нь буурсан уу?
- Нойр нь хямарч байна уу?

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсэхийг үнэлэх шалгуур

Бүлэг	Онцлог	Жишээ
Хэвийн	Үзлэгээр бүтцийн өөрчлөлтгүй. Хүчирхийлэлд өртсөн боловч тэр дороо үзүүлээгүй хүүхдүүдийн 80%-д нь өөрчлөлт илэрдэггүй. Гэхдээ энэ нь хүчирхийлэлд өртөөгүй гэсэн үг биш.	Сорвижсон гэмтэлтэй боловч охин хальсанд ялимгүй тэгш бус ан цав гарах нь хэвийн үзүүлэлтийн нэг юм.
Өвөрмөц бус*	Бэлгийн хүчирхийллийн улмаас үүсч болох боловч хүчирхийлэлд өртөөгүй хүүхдэд ч илэрч болох шинжүүд	<ul style="list-style-type: none"> • Охин хальс, түүний орчимд тархмал улайлт байх
Магадлалтай буюу өвөрмөц	Ихэвчлэн хүчирхийллийн дүнд үүсдэг боловч хүчирхийллийн бус анамнезтай байхад илэрч болох шинжүүд	<ul style="list-style-type: none"> • Герпес төст бэлгийн замын халдварт өвчнүүд • Охин хальсны шарх, зулгарал • Охин хальсны арын өргөн нь нарийсах
Нотлох баримт	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн үед л илэрдэг шинжүүд. Хүүхэд хүчирхийлэлд өртсөнөө мэдэгдээгүй байсан ч тухайн шинжүүдээр бэлгийн хавьтал болсныг батлана.	<ul style="list-style-type: none"> • Охин хальс, үтрээний урагдал • Үрийн шингэн илрэх • Тэмбүү, заг хүйтэн (төрөлхийн бус) • Охин хальсгүй байх • Жирэмсэн байх
Хүчирхийлэлтэй холбоогүй	Хэвийн биш боловч ямар нэг байдлаар хүчирхийлэлтэй холбогдохгүй шинжүүд	<ul style="list-style-type: none"> • Санамсаргүй гэмтлийн дараа (найдвартай гэрчийн үгээр) үүссэн бэлгийн уруулын цус хуралт

**хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэдгээ илчилбэл өвөрмөц бус шинжүүд нь өвөрмөц шинж болдог.*

Биеийн болон сэтгэцийн байдлыг үнэлэх үзлэгийг зохих зааврын дагуу хийж, дээрх шинжүүдийн илрэлийг үнэлж, тухайн хүүхэд хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн байж болзошгүй нь тогтоогдвол нэн даруй хамтарсан багийн гишүүд, ялангуяа нийгмийн ажилтан, хэсгийн байцаагчид мэдэгдэнэ.

Үзлэгийн тэмдэглэлийг тодорхой хөтлөн, боломжтой бол хүчирхийллийн ул мөрийг баримтжуулан, шаардлагатай анхан шатны тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулна. Тухайлбал:

1. Бие махбодын хүчирхийллийн улмаас үүссэн байж болохуйц гэмтэл бэртэл, түлэгдэлтийн хүнд хөнгөний зэргээс хамааран нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ шаардагдахааргүй байвал өрх, сумын эмнэлгийн нөхцөлд анхдагч цэгцлэлт хийж, ариутгаж цэвэрлэн, цэвэр боолт хийнэ. Шархны эдгэрэлтийн байдлаас хамаарч тодорхой хугацаанд хянана. Гэрийн нөхцөлд эмчлэх боломжтой түлэгдэлтийн шарханд гар доорх энгийн эм түрхлэг (Хоромхон, чацарганы тос, панкепсинтэй тос.. гэх мэт) түрхэхийг зөвлөнө. Биеийн эсэргүүцлийг сайжруулах, дархлаа дэмжих энгийн эмчилгээ, витамин эмчилгээг зөвлөнө.

2. Өсөлтийн бэрхшээлтэй хүүхдэд хангалттай хоол өгч сувилахад хурдан жиндээ хүрдэг.
3. Толгой, хэвлийн гэмтэл бэртэл, дотуур цус алдалтын шинж илэрсэн, ясны гэмтэл үүссэн болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байгаа тохиолдолд нэн даруй нарийн мэргэжлийн эмчийн тусламжид илгээнэ.
4. Хүүхэд ноцтой хүнд гэмтэл авсны улмаас ухаангүй байгаа, бэлгийн хүчирхийлэлд өртсөн, амиа егүүтгэхийг завдсан зэрэг тохиолдолд яаралтай тусламжийн үйлчилгээг үзүүлэх, хамгаалах арга хэмжээ авч, Улаанбаатар хотод байгаа бол холбогдох мэргэжлийн эмнэлэгт, аймгийн төвүүдэд бол мэс засал гэх мэт мэргэжлийн тасгуудад, сумын түвшинд бол сумын эмнэлэгт, нарийн мэргэжлийн эмчилгээ оношилгоо шаардлагатай бол аймгийн нэгдсэн эмнэлэг болон бүсийн оношилгоо эмчилгээний төвд хүргүүлнэ.
5. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй тохиолдолд биеийн үзлэгийг зохих зааврын дагуу боломжийн хэмжээнд хийж, тэмдэглэлийг нарийвчилан бичиж, баримтжуулна. Шүүхийн шинжээч эмч рүү илгээнэ.
6. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг зохих хуваарийн дагуу хянаж, шаардлагатай үед тогтмол хугацаанд хяналтын үзлэгт хамруулж болно.



Шаардлагатай тохиолдолд шүүхийн шатанд баримт болох мэдээллийг бүрдүүлэх тухай

Хүүхдийн өсөлт хөгжил хэвийн бус байгаа үед /хүүхэд үл хайхрагдсан/ өгөх зөвлөгөө, дэмжлэг тусламжууд, холбон зуучлах

- Хүүхдийн хэвийн өсөлт хөгжлийн наад захын энгийн шалгуурын талаар асран хамгаалагч нарт мэдээлэл өгөх
- Хэвийн байдалд эргэн оруулахын тулд хэрхэн харилцах, юуг анхаарах тухай зөвлөгөө өгөх
- Нийгэм сэтгэлзүйн дэмжлэг хэрхэн үзүүлэх зөвлөгөө өгөх
- Хамтран ажиллах, хандаж болох байгууллагын тухай мэдээлэл өгөх
- Харьяа баг/хороо/сумын нийгмийн ажилтанд хандах

Ахуйн осол гэмтлийг хүчирхийллээс ялгах

Ахуйн осол гэмтэл ба хүчирхийлэлийн гэмтэл бэртэлийн ялгаатай байдал

Гэмтэл бэртэлийн шинж	Хүчирхийллээс үүдэлтэй бол	Ахуйн ослоос үүдэлтэй бол
Хөхрөлт	Өгзөг, хонго, гуяны ард, тахим тушаа, хэвлийн гадна тал, бэлэг эрхтэн зэрэг далд газар болон хацар, чихний гэдэс, дээд уруул, бугалга ба шууны дотор тал, хүзүү зэрэг нүдэнд ил харагдах биеийн хэсэгт хөхрөлт үүсэх нь голдуу бие махбодын хүчирхийлэлтэй холбоотой. Хүчирхийллийн үед юу хэрэглэсэнээс хамааран янз бүрийн хэлбэртэй хөхрөлт үүсэх ба эдгэрэлтийн харилцан адилгүй үе шатанд яваа, ахин давтагдсан шинжтэй хөхрөлт байдаг. Мөн хөхрөлт нь шүд, хуруу, гогцоорсон язралттай ором дагалдсан, сорви үлдээсэн байх нь хүчирхийлэлтэй холбоотой.	Бүх насны хүүхдийн өвдөг, тохой, шуу, шилбэ, дух эрүү зэрэг хэсгүүдэд хөхрөлт голдуу үүсдэг. Ялангуяа өвдөг шилбэ хамгийн их өртдөг. Мөлхөж сурч байхдаа, хөлд орж эхлэх үедээ хүүхэд духаа хамгийн их хөхрүүлдэг. Бүдрэх болон унахад дугуйдуу хэлбэртэй тодорхойлох онцлог байхгүй хэв шинжит хөхрөлт үүсгэнэ. Дөнгөж төрсөн нярай эхэндээ хацар, чих, хамар, нүдээ маажсанаас энгийн шарх, маажсан орыг үлдээдэг ба хумсыг нь тогтмол авч байвал дахин давтагдахгүй.
Түлэгдэлт	Санаатайгаар үүсгэсэн, тамхины түлэгдэлт нь дугуй хэлбэртэй, хэвээр дарсан мэт, хэмжээний хувьд нэг хэвийн байдаг. Халуун зүйл рүү түлхэгдсэн хүүхдийн түлэгдэлт нь ихэвчлэн 2 зэргийн, цэврүүгүй байна. Бэлэг эрхтэн, хошного санамсаргүй байдлаар түлэгдэх нь маш ховор.	Хүүхэд хуруу болон алгаараа аливаа зүйлийг туршиж үздэг тул энэ хэсгийн түлэгдэлт нь голдуу санамсаргүй тохиолдлоор үүсэх магадлалтай. Мөн санамсаргүй байдлаар үүссэн түлэгдэлтээс голдуу үсэргэсэн, цацарсан хэлбэртэй тодорхой зааггүй ул мөр үлдэх талтай. Хүүхэд гэнэтийн тохиолдлоор халуун зүйлд түлэгдвэл рефлексээрээ холддог тул түлэгдэлтийн хүнд, хөнгөн нь түлсэн зүйл хэр халуун байсан, ямар хугацаанд байснаас хамаарна.
Толгойн бэртэл гэмтэл	Толгойн хэсэгт цусан хавдар үүсэх нь ихэнхдээ гадны нөлөөтэй байдаг. Толгойд хэд хэдэн газар нэгээс илүү гэмтэл үүсэх, том том халцархайнууд үүсэх зэрэг нь хүчирхийлэлтэй холбоотой байх нь түгээмэл.	Цусан хавдар бүр толгой руу цохисноос үүсдэггүй ба энэ өвчнөөр өвдсөн хүүхдийн тэн хагасаас илүү хувьд нь гавлын ясны бэртэл харагдахуйц гэмтэл байдаггүй.
Ясны бэртэл гэмтэл	Мушгирч үүссэн ясны бэртэл, яс хагарч хэлтэрсэн байх, дал, эгэм, хавирга, өвчүү гэмтэх зэрэг нь голдуу санаатай үүсгэгдсэн байх магадлалтай.	Бага насны хүүхэд газар унахдаа аль нэг ясаа хугалахаар хүчтэй унадаггүй бөгөөд яс хугарч гэмтэхээр тийм өндөрт гарч чаддаггүй. Дөнгөж хөлд орж байгаа хүүхэд гүйж байхдаа нэг хөлдөө тээглэж унах үед ховор тохиолдолд мушгирсан хугарал тохиолдож болно.

Таны анхааран ажиглах зүйлс:

- Хүүхдийн биеийн аль хэсэгт гэмтэл бэртэл үүссэн байгаа вэ?
- Гэмтэл бэртэл болон сорвины харагдах байдал болон хэмжээ нь ямар байна вэ?
- Гэмтэл бэртэл хэрхэн бий болсон талаарх асран хамгаалагчийн өгч буй тайлбар нь тухайн хүүхдэд илэрч буй шинжүүдтэй тохирч байгаа эсэх?
- Гэмтэл бэртэлийн эдгэрэлтийн төлөв байдал болон давтагдсан гэмтэл бэртэлийн байдал зэрэг шинж байдалд дүгнэлт хийснээр тухайн хүүхдэд үүссэн гэмтэл бэртэл нь энгийн ахуйн ослоос үүдэлтэй юу?, аль эсвэл хүчирхийлэлээс үүдэлтэй юу? гэдгийг ялган тогтоох боломжийг олгоно.
- Хүүхдийн бие дээр ил харагдах бэртэл гэмтэл (хөхрөлт, улайлт, хавдсан, цохигдсон, зүсэгдсэн, түлэгдсэн шарх, яс цуурсан байдал, шүдний ор, мөр г.м)–ийн шинжүүд бий эсэхийг шалгах
- Эдгээр шинж нь тухайн бэртэл гэмтэлийг үүсгэсэн гэх шалтгаантай тохирч буй эсэхийг тодруулах
- Нэг бус удаа ижил төрлийн гэмтэлд өртсөн байдлыг илтгэх эдгэрэлтийн янз бүрийн шатанд байгаа гурав ба түүнээс дээш бэртэл гэмтлүүд үзлэгээр илрэх зэрэг нь тухайн хүүхэд хүчирхийлэлд өртсөн байж болзошгүйг илтгэдэг.
- Ахуйн санамсаргүй ослоос үүссэн гэмтэл бэртэл нь хүүхэдтэй зүй бус харилцсанаас болж үүсдэг (хөхрөлт, түлэгдэлт, толгой хэвлийн хөндийн гэмтэл, ясны бэртэл, өсөлтийн бэрхшээл зэрэг) гэмтэл бэртэлийн үндсэн хэв шинжүүдэд өөр өөр хэлбэрээр илэрдэг.

Ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаарх зөвлөгөө өгөх, сэрэмжлүүлэх тухай

- Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогоос хамааран, бидний амьдарч буй өрөө тасалгаа эрсдэл учруулах боломжтой байдаг. Тухайлбал, бага насны хүүхэд ахуйн аливаа осол, бэртэлд өртөх эрсдэл хамгийн ихтэй хэсэг бол гал тогооны өрөө буюу пийшин, зуух тойрсон хэсэг юм. Энд халуун цай, иртэй хутга, хагархай аяга шаазан, шилэн эдлэл, цахилгаан хэрэгсэл зэрэг аюултай эд зүйлс байх ба гэрийн тавилга хэрэгслийн таглаа, хаалга, дамжиж гарахуйц байрлалтай тавилга сэлт нь хүүхдийг осол гэмтэлд хүргэж болох эрсдлийг үүсгэнэ;
- Мөн харанхуй гудамж, эзэнгүй хашаа байшинд тоглох зэрэг нь хүчирхийлэлд өртүүлж болзошгүй орчин болно;
- Ихэнх осол гэмтэл нь хүүхдийг хараа хяналтгүй орхисон үед болдог тул аяга таваг, сав суулга хийдэг шүүгээнүүдээ сайтар түгжиж, хоол цайгаа буцалж байхад нь орхиж гарахгүй байх хэрэгтэй. Иртэй зүйлс, амархан хагарч гэмтэх эд зүйлс, ахуйн ариун цэвэр, угаалга цэвэрлэгээнд ашигладаг бодис, бэлдмэлийг хүүхдийн гар хүрэхээргүй газарт байрлуулвал зохино;
- Хүүхдийн тоглоомын талбай, тоглож буй тоглоом нь аюулгүй байдал, зохих стандартыг хангасан байх шаардлагатай ба залгих, шидэх, хахах, хамар амаа бөглөх мэтийн эрсдэл үүсгэхүйц жижигхэн чулуу, эд зүйлс осол гэмтэл үүсгэх эрсдэл дагуулахыг эцэг эх сайтар анхаарч байх хэрэгтэй;

- Өндөр хашаа, байшин, машины грааж дээр гарч гүйлдэх, хурц шовх үзүүртэй хашааны мод, төмөр шон гэх мэт зүйл рүү авирах зэрэг нь бэртэл гэмтэл үүсгэх эрсдэлтэйг хүүхэддээ анхааруулж, аль болох эрсдэлгүй орчин нөхцөлд тоглохыг байнга сануулж байх нь зүйтэй.

Өрхийн эмнэлэгт хэрэглэгддэг маягт, дүрэм журам дахь хүүхэд хамгааллын асуудлуудад, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх хэрэгтэй.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, мэдээлэх талаар хороо баг, сумын түвшинд ажиллаж буй эмч нарт хэрэгтэй хууль тогтоомж, дүрэм журам,

- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (4-р бүлэг, 13-р зүйл)
- Хүүхдийн эрхийн тухай конвенц
- Эрүүл мэндийн тухай хууль (6-р бүлэг, 28-р зүйлийн 28.4.2)
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ

"6.14. Эмнэлгийн мэргэжилтэн нь өөрийн үйлчлүүлэгчид хүчирхийллийн (бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны г.м) шинж тэмдэг байгаа эсэхийг байнга анхаарч, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад мэдээлж, таслан зогсоох, давтагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллана. Хүчирхийлэлд өртөх эрсдэл бүхий хүмүүстэй ажилладаг эмнэлгийн мэргэжилтнүүд хүчирхийллийг илрүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, тэдэнтэй харилцах талаар мэдлэгтэй байвал зохино."

- Хувь хүний нууцын тухай хууль (3-р бүлэг, 6-р зүйл)

Хүүхдийн нууцлалыг хангах нь

- Эмч хүний хувьд өргөсөн тангараг, эмчийн ёс зүйн хэм хэмжээний дагуу үйлчлүүлэгчийнхээ нууцлалыг хадгалах нь чухал. Ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртсөн үед нууцлалыг сайн хадгалж, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай. Учир нь нийтийн дунд тархсан түгээмэл ойлголтоор бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг буруутгах хандлагатай. Тийм учраас бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд өөрт тохиолдсон явдлыг нуун дарагдуулах, хүнд хэлэхээс айж эмээх, ичиж зовдог.
- Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлд нууцыг нь хэнд ч хэлэхгүй гэж хэлж болохгүй. Учир нь та хамтарсан багийн бусад гишүүдийн дэмжлэг, үйлчилгээг авахын тулд зайлшгүй өөр хэн нэгэнд хэлж таарна. Тиймээс хүүхэд тухайн асуудлаар ямар мэргэжилтэнд хандаж, ямар үйлчилгээ авахыг нарийн хэлж, тайлбарлан ойлгуулснаар хамгааллын үйлчилгээг цогц байдлаар хамтарсан багийн гишүүдээс авах боломжийг бүрдүүлнэ. Та хүүхэд маш тодорхой тайлбарлаарай. Жишээлбэл: "Хорооны нийгмийн ажилтан, цагдаагийн ажилтан хоёрт заавал мэдээлэх ёстой. Учир нь энэ бол миний үүрэг. Хүүхэд хамгааллын тухай хуулиар эмч хүн ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид заавал мэдээлнэ гэсэн байдаг юм. Тэр хүмүүс ч бас өөрийн гэсэн чамд туслах, үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Энэ тохиолдолд чиний нууцыг биднээс өөр

хэн нэгэнд хэлэхгүй, задруулахгүй. Хэнд ч хэлэхгүй, нуун дарагдуулбал чиний эрүүл мэнд, амь насанд аюултай учраас, чи тусламж авах эрхтэй...” гэх мэтээр сайн тайлбарлаж таниулна.

7 дугаар зүйл. Хүүхдийн хамгаалуулах эрх

7.1. Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй.

7.3. Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхтэй.

Хүүхдийн эрхийн тухай хууль

Хоёрдугаар бүлэг: Хувь хүний нууцын төрөл, хувь хүний нууцыг хамгаалах

4 дүгээр зүйл. Хувь хүний нууцын төрөл

1. Хувь хүний нууц нь дараахь төрөлтэй байна:

1. захидал харилцааны нууц;
2. эрүүл мэндийн нууц;
3. хөрөнгийн нууц;
4. гэр бүлийн нууц;
5. хуулиар тогтоосон бусад нууц.

4. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчин” гэдэгт хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчин хамаарахгүй.

5 дугаар зүйл. Хувь хүний нууцыг хамгаалах

1. Хувь хүн нууцаа өөрөө хамгаална.
2. Шаардлагатай тохиолдолд хувь хүний нууцыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага хамгаалалтдаа авч болно.
3. Хуулиар тусгайлан эрх олгогдсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хувь хүний нууцтай танилцана.
4. Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно.

Хувь хүний нууцын тухай хууль

Эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйн хэм хэмжээ

- 3.10 Эмнэлгийн байгууллага, эмнэлгийн бусад мэргэжилтний нэр төр, мэргэжлийн ур чадвар болон үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой аливаа мэдээллийг санамсаргүй буюу санаатайгаар хөндлөнгийн хүмүүст болон тэдний дэргэд дэлгэн ярих, шүүмжлэн ярихгүй;
- 3.13 Өвчний түүх болон үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой бичиг баримтыг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах буюу ашиглуулахгүй;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ. Эрүүл мэндийн сайдын 2013 оны II сарын 25-ны өдрийн 446 дугаар тушаалын I дүгээр хавсралт

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүнийг эмчлэн оношлосон тухайгаа тайлагнах нь:

Өрхийн эмч хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлтэй ажилласан, зөвлөгөө өгсөн, эмчилсэн бол сар бүрийн бүртгэл, тоо баримтадаа оруулж удирдах байгууллагад мэдээлж байх ёстой. Мөн хороо, баг, сумын түвшинд ажиллаж буй хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдэд ялангуяа нийгмийн ажилтанд мэдээлж хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хамгаалах үүргээ гүйцэтгэнэ.

НОМ ЗҮЙ

- А.Батхишиг, С.Энхтуяа (2011). Хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нь. УБ
- А.Батхишиг, О.Мягмар, М.Нямдорж. (2009). Хүүхэд хамгааллын үйлчилгээ. УБ
- С.Энхтуяа. (2009). Хүүхэд хамгааллын үндэс. УБ
- The Scottish Government (2013). *Child protection guidance for health professionals*, Edinburgh



Хүүхэд хамгааллын тогтолцооны загварыг (хүүхэд хамгааллын хамтарсан багийг) анхан шатны нэгжид (нийслэл, дүүрэг хороонд, орон нутаг сум, багт) бэхжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 23, 27-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 2,10-р хороо, Чингэлтэй дүүргийн 9,10-р хороо болон Архангай аймгийн Хайрхан, Батцэнгэл сум, Эрдэнэбулган сумын 4-р багийг сонгон хэрэгжүүлж байна. Тус төсөл нь 2015- 2018 оны хооронд ЖАЙКА-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжих юм.

Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна:

Үйл ажиллагаа 1: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх

Үйл ажиллагаа 2: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн болон салбар дундын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах

Үйл ажиллагаа 3: Олон нийтийн дунд хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх

Үйл ажиллагаа 4: Төслийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны сургамж, хүрсэн амжилт, үр дүнд үндэслэн холбогдох яамдад нөлөөлөх

Төслөөс хүлээж буй үр дүн:

- Хамтарсан багийн гишүүд нь мэргэжлийн ур чадвар болон хүүхэд хамгааллын үйлчилгээний арга зүйн мэдлэгээ сайжруулж, зорилтот орон нутаг дахь хүүхдүүдэд хамтарсан багаар хамгааллын үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон байна.
- Хүүхэд хамгааллын тогтолцооны хүрээнд байгууллага хоорондын уялдаа холбоо зохицуулалтыг хангах механизм бий болж, бэхжиж хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэхээс гадна зорилтот орон нутагт хүүхдийн эсрэг хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээг цаг алдалгүй хүргэх боломж нэмэгдэнэ.
- Хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй хүүхдүүд ба тэдний эцэг эх, асран хамгаалагчдын хоорондын харилцааг сайжруулахад дэмжих, хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлнэ.
- Үндэсний болон орон нутгийн түвшин дэх төрийн байгууллагуудын зүгээс хүүхэд хамгааллын үйлчилгээнд ач холбогдол өгч ажиллах нь нэмэгдсэн байна.